



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 06 өдөр

Дугаар АА22

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны XXV/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Өвсний нөөц бүрдүүлэх" нийлүүлэх нийлүүлэгчээр шалгарсан "Мөнх тунгалаг тамир хоршоо"-той 89,937,500 (Наян есөн сая есөн зуун гучин долоон мянга таван зуун) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заасан барааг холбогдох хууль, журам, стандартын дагуу бэлтгэн, тээврийн зардлыг бүрэн хариуцаж захиалагчийн заасан цэгт буулган хүлээлгэн өгөхийг "Мөнх тунгалаг тамир хоршоо"-ны захирал (Б.Бадарч)-д үүрэг болгосугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

4. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж чанар стандарт, жин, хэмжээ, сав, баглаа боодол тоо ширхгийн дагуу хүлээн авч хадгалалт, хуваарилалтад хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ч.Амгалан), Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн дарга (М.Лхагваням) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Засаг Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324011028

Аймгийн Засаг даргын 2024 оны  
11 дүгээр сарын 06-ны өдрийн А/А22 дугаар  
захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Баталгаат хугацаа	1 жил	М.Лхагваням
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна.	Д.Батцогт